



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/41

Шивээговь сум

Шинэчилсэн бүртгэл, тооллогын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар хуралдааны тэмдэглэл, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай” А/57/48 хамтарсан тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/86 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 18 хоногт багтаан зохион байгуулсугай.

2.Шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Шинэбаяр

(Цагдаагийн хэсгийн дэслэгч,
зохицуулагч)

Гишүүн:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг дарга)

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Маналмаа

(2 дугаар багийн Засаг дарга)

3.Шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.


4.Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2023 оны 03-р сарын 30 ний өдрийн А/41 дугаар захирамжийн хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ, ҮЗЛЭГ
ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. Зорилго

Авто тээврийн тухай хууль, Авот замын тухай хууль, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, Агаарын бохирдорлын төлбөрийн тухай хууль болон “ Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтанд тусгагдсан сүүлийн 1-4 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгсэлийн шингэчилсэн бүртгэл, тоолгод хамруулхад оршино .

1. Автатээврийн тухай хууль
2. Авто замын тухай хууль
3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
4. Агаар бохирдолын төлбөрийн тухай хууль
5. Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 03дугаар сарын 03-ны өдрийн “ Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай “ А/57/48 тушаал, Аймгийн засаг даргын А/86 дугаар захирамж
6. “ Автотээврийн үндэсний төв “ ТӨҮГ-ын тээврийн хэрэгсэлийн бүртгэлийн хэлтэсээс ирүүлсэн сүүлийн 1-4 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгсэлийн жагсаалт
7. Жагсаалтанд тусгагдсан тухайн багийн нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгсэлүүдийг байршил хаягын мэдээллийг урьдчилан бэлтгэж ажлын хэсгийг мэдээллээр хангах
8. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад бүртгэл тооллогын талаархи мэдээ, мэдээллийг нэгтгэж тайлагнах
9. Багийн дарга нар тутаг дэвсгэртээ байгаа хасагдах тээврийн хэрэгсэлийн бүртгэлийг шинэчилэн гаргаж, бүртгэлээс хасах тээврийн хэрэгслүүдийг холбогдох баримт материалыг бүрдүүлж мэргэжлийн байгуулгад хүргүүлнэ,

ХОЁР : Хугацаа

Сумын хэмжээнд тоологдох 172 тээврийн хэрэгслийг 2023 оны 03-р сарын 30-ны өдрөөс эхлэн 2023 оны 04-р сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд тооллогийг зохион байгуулах.